



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 2/08

Дэлгэрхаан сум

**Шар усны аюулаас хамгаалах урьдчилан
сэргийлэх ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 286, 303 дугаар тогтоол, Улсын их хурлын 2011 оны 340 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн "Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж"-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	-Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	-Байгаль хамгаалагч -Цаг уурын харуул -Хөдөө аж ахуйн мэргэжилтэн -1,2,4,5-р багийн Засаг дарга нар
Нарийн бичиг:	-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2. Гол, мөрөн, нуурын арал, тохой, эрэг дагуу болон уулын ам бэл, жалга, сувгийн ойролцоох айл өрхийн судалгааг гарган сэрэмжлүүлгийг хүргэн шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Засаг даргын гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, удирдамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

